



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэврэй сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2022/77/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

СЭВРЭЙ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
ДАЛТАНСҮХ ТАНАА

2022.02.23 № 194
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Өмнөговь аймгийн Сэврэй сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Сэврэй сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-02-23 №193

01600005

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	43.80	142.40
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	447.10	580.40
	Нийт хөрөнгийн дүн	490.90	722.80
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	490.90	722.80
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	490.90	722.80
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	437.50	919.70
	Үйл ажиллагааны зардлын дүн	471.20	669.20
	Үйл ажиллагааны үр дүн	- 33.70	250.50
	Үйл ажиллагааны бус үр дүн	- 2.60	- 18.60
	Үйл ажиллагааны нийт үр дүн	- 36.30	231.90
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	490.90	490.90
	Тайлант оны үр дүн		231.90
	Эцсийн үлдэгдэл	490.90	722.80
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	374.50	498.70
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	374.50	486.20
	Үйл ажиллагааны ЦМГ	-	12.50
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	12.50
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	12.50
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	398.50	379.90
	Урсгал зардал	398.50	379.90
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	398.50	392.40
	Улсын төсвөөс санхүүжих	353.20	353.20
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24.90	24.20
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжих	20.40	15.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай түргэн шуурхай хүргэх зорилго тавин ажилласан байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал болон алслагдсан суманд очиж ажиллах санхүү, хүний нөөц, цаг хугацааны хувьд боломжгүй байсан тул байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, бараа материал, үндсэн хөрөнгийн биет тооллого хийх, төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж байсныг дурдах нь зүйтэй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Бараа материалын эм боох материалын үлдэгдэлд 0.5 сая төгрөг, хүнсний материалын үлдэгдэлд 0.012 сая төгрөгийг тус тус хасах дүнгээр илэрхийлсэн нь нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтлөөгүй, 2021 оны 06 сарын 28-нд 60-78 ӨМЭ улсын дугаартай Ландкрузер 105 авто машиныг шилжүүлэн авч он дуустал 22,669 км гүйлттэй ашигласан ба улмаар 2021 оны 10 сарын 8-нд Мэжик Сэндс ХХК-аас 4 ширхэг дугуйг 2.0 сая төгрөгөөр шинээр авсан ба жилийн эцэст 2021 оны 12 сарын 20-нд ЭМТ-ийн нийгмийн ажилтан Ө.Олзвойгоос 5 ширхэг дугуйг 2.7 сая төгрөгөөр худалдан авсан нь резинэн дугуйн эдэлгээний нормыг баримтлаагүй, төсвийн хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулаагүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд 150 мэдээлэл байршуулахаас 13 мэдээлэл хугацаа хоцруулан байршуулсан, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулаагүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 40.7 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээг өссөн дүнгээр мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 90.0 сая төгрөгийн 6 ажил гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 28.2 сая төгрөгийн 4 ажил гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1.5, 6.4.4, 6.4.5-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эмийн зарцуулалттай, бараа материалын тайланг тулгах, хэвтэн эмчлүүлэгчийн зардлыг хянан баталгаажуулах

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 208.97 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 46.7 сая төгрөгийн алдааг залруулж, 162.2 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 0.07 сая төгрөгийн зөрчилд төсвийн сахилга батыг сайжруулах 3 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн аудитаар	8	50.07	3	46.7			2	3.3	3	0.07
2	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	1	158.9					1	158.9		
3	Нийт дүн	9	208.9	3	46.7			3	162.2	3	0.07